

ГАДААД ХЭЛНИЙ СУРГАЛТ БА ОРЧИН ҮЕИЙН УХААЛАГ ТЕХНОЛОГИЙН ХЭРЭГЛЭЭ

FOREIGN LANGUAGE TRAINING AND USING OF MODERN SMART TECHNOLOGY



Ц.ДЭЛГЭРЦЭЦЭГ

Хууль сахиулахын их сургуулийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн
Гадаад хэлний тэнхимийн ахлах багш, цагдаагийн ахмад

DELGERTSETSEG T.

Senior lecturer of Foreign language department, Institute of Law and Social
sciences, Law Enforcement University, Police captain

Товч агуулга: Хүний хэл сэтгэлгээний судалгаа сүүлийн 60 гаруй жил цахим тооцооны хэрэгсэл ашиглаж эхэлснээс хойш урьд өмнө байгаагүй эрчимтэй хөгжиж байна. Сургалтад орчин үеийн ухаалаг технологийг ашиглах нь багш нарын ажлыг хөнгөвчлөх, цаг хэмнэх зэрэг олон талын ач холбогдолтой болсныг манай эрдэмтэн судлаачид сайн мэднэ. Харин тэдгээрийг нарийн судалж үр дүнг онцолсны үндсэн дээр сургалтад нэвтрүүлэх чухал байдаг тул энэ удаад бид зөвхөн гадаад хэлний төдийгүй бусад төрлийн хичээлд ч өргөн хэрэглэдэг орчин үеийн компьютерын лингафоны кабинетыг онцлон судалж та бүхэнд хүргэхийг зорилоо. Ийм кабинет гадаад хэл сурахад шинэ дэвшилтэт арга нэвтрүүлэх сайхан боломж олгодгоороо онцлог байдаг.

Abstract: In this article we would like to emphasize modern language laboratory and benefits of modern technology to facilitate the work and save time. This cabinet is also addresses a unique opportunity to introduce a new and advanced way to learn a foreign language.

Түлхүүр үгс: Аудио-видео сургалтын арга хэлбэрүүд, хэлний лабораториудыг сайжруулж шинэчлэх, илүү цогцоор нь, хянах, шалгалт авах, нэг зэрэг олон оюутанд түгээх, багаар ажиллах, дэлгэц, дахин ярилцаж мэдээллийг цуглуулах, видео, веб дээр суурилсан мультимедиа, сүлжээ

Key words: Audio-lingual method, developments in language labs, more complex, monitor, control, deliver, group, display, review and collect, audio, video and web based multimedia content

ОРШИЛ

Орчин үеийн лингафоны кабинет түүнийг гадаад хэлний сургалтад хэрхэн үр дүнтэй ашиглах боломжийн талаар ярилцахын өмнө бид лингафоны кабинетын талаарх ерөнхий ойлголт ба орчин үеийн лингафоны кабинет гэж юуг хэлээд байгаа юм бэ? Дэлхийн зах зээл дээр өнөөдөр ямар төрлийн лингафоны кабинетуудыг санал болгож байна вэ? Бид өөрийн сургуулийн

лингафоны кабинетаа шинэчилж, лингафоны кабинетыг гадаад хэлний сургалтад үр дүнтэй хэрэглэхийн тулд гадаадын ямар туршлага ашиглавал зүйтэй вэ? Манай нөхцөлд ямар замаар явбал эдийн засгийн хувьд үр ашигтай, цаашид техникийн дэмжлэгийг авах боломжтой, илүү ирээдүйтэй байх вэ зэрэг асуултад хариулт өгөх нь зүйтэй.

Лингафоны кабинет буюу барууны орнуудад хэлний лаборатори гэж



Хууль сахиулахын их сургууль



нэрлэдэг аудио-видео төхөөрөмжүүдийг орчин үеийн гадаад хэлний сургалтад өргөнөөр хэрэглэсээр иржээ. Анхны лингафоны кабинетыг бүр эрт 1922 онд Францын Греноблийн их сургуульд байгуулан ажиллуулж байсан гэж үздэг. Харин 1950-1960-аад онд аудио бичлэг хийх, эргээд сэргээх боломжтой магнитофон төхөөрөмжүүд өргөн дэлгэрснээр лингафоны кабинетуудын гадаад хэлний сургалтад ашиглах болж, улмаар дэлхийн их, дээд сургууль, коллеж, техник мэргэжлийн сургуулиудад зайлшгүй байх ёстой бүрэлдэхүүн хэсгүүдийн нэг болжээ.

Лингафоны кабинетуудын ачаар оюутнуудад гадаад хэлний зөв дуудлагыг богино хугацаанд заах, оюутнуудыг гадаад орчны дуу шуугианаас тусгаарласнаар цэвэр аудио авиаг сонсох, магнитофоны бичлэг ашиглан тухайн хэлээр ярьдаг үндэсний хүмүүсийн яриа, кино, жүжгийн бичлэг, дикторын уншилт зэргийг ашиглан сургах боломжтой зэрэг олон давуу тал бий болсон байна. Үүнээс гадна, лингафоны кабинет байгуулахад бага зардал гардаг, энгийн төхөөрөмж, цахилгаан техникийн хялбар холболт зэргийг ашигладаг учраас угсрахад амархан байдаг байна.

Харин 1970-80-аад оны үед уламжлалт лингафоны кабинетуудын хувьд нилээд дутагдалтай тал анзаарч эхэлсэн байна. Тэр үеийн лингафоны кабинетууд зөвхөн хоёр талын бичлэгтэй магнитофон төхөөрөмж дээр суурилж байсан болохоор багшаас оюутанд гэсэн ганцхан чиглэлийн сургалт байсан нь оюутны зүгээс ямар нэг идэвх гаргах боломж өгдөггүй байжээ. Тухайлбал, оюутнууд багшаас өгсөн сургалтын материалыг өөрөө дахин уншуулах, зарим муу сонсогдсон хэсгүүдийг эргэж сонсох боломж муутай байсан юм. Мөн бичлэгийг дахин сонсохын тулд магнитофоны хальсыг дахин эргүүлэх хэрэг гардаг учраас энэ нь сургалтын цагийг хий дэмий гарзадсан хэрэг болдог байжээ.

1990-ээд оны үед компьютерын технологийн үсрэнгүй хөгжлийн ачаар лингафоны кабинетууд өөрийн хөгжлийн мультимедиа эрин үедээ

орж иржээ. Үүний үр дүнд орчин үеийн лингафоны кабинетуудад зөвхөн аудио бичлэг төдийгүй видео бичлэг бүхий сургалтын материалыг хэрэглэх боломж гарч ирсэн байна. Ийм учраас орчин үеийн лингафоны кабинет гэдэг нэртэй холбоотойгоор бид сүлжээнд холбогдсон мультимедиа компьютеруудыг авч үзэх нь зүйтэй юм.

ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭР САНАЛ БОЛГОЖ БУЙ ЛИНГАФОНЫ КАБИНЕТУУД:

Дэлхийн зах зээл дээр санал болгож буй лингафоны кабинетуудыг үндсэнд нь 5 хэсэгт хуваан үзэж болно. Үүнд:

1. Аналог лингафоны кабинет
2. Мультимедиа боломж бүхий лингафоны кабинет
3. Компьютерын лингафоны кабинет
4. Мобильный буюу нүүдлийн компьютерын кабинет
5. Тоон технологийн лингафоны кабинет.

Эдгээр кабинетуудын давуу ба дутагдалтай талуудыг авч үзье. Орчин үеийн аналог лингафоны кабинетуудыг радио электроникийн техникийн хамгийн сүүлийн үеийн ололт дээр тулгуурлан хийжээ. Сургалтын материалыг сурагчдад хүргэхийн тулд багшийн ширээ нь кассетын магнитофон, бага оврын CD-DVD тоглуулагч зэргээр тоногложээ. Харин сурагчдын ширээ нь флеш санах ой бүхий тоон диктофон төхөөрөмжтэй байж болдог байна. Хоёр сургалтын программыг багш нэгэн зэрэг ажиллуулах боломжтой. Энэхүү лингафоны кабинетын нэг сайн тал нь бүх төхөөрөмж нь маш энгийн учраас ямар нэг тусгай бэлтгэлгүйгээр уг кабинетыг хялбар ажиллуулах боломжтой байдаг оршино. Гэхдээ иймэрхүү лингафоны кабинет 1960-1970-аад оны техникийн түвшинд байгаа учраас цаашид өргөжүүлэн хөгжүүлэх ямар нэг боломжгүй ажээ.

Дэлхийн зах зээл дээр санал болгож байгаа хоёр дахь төрлийн лингафоны кабинет бол нэмэлт мультимедиа боломж бүхий аналог техниктэй юм. Энд техник төхөөрөмж нь түрүүчийн дурдсан лингафоны кабинеттай адилхан хэдий ч нэмэлт мультимедиа



МОНГОЛ
УЛСЫН
ХҮҮЛЬ
САХИУЛАХ
УРГАХ

төхөөрөмж угсрагддагаараа ялгаатай. Үүнд мультимедиа проектор болон багшид зориулсан персонал компьютер орно. Аналог лингафоны кабинетын бүх үйл ажиллагааг багшийн ажлын байранд суурилуулсан персонал компьютераас удирддаг учраас ийм төрлийн лингафоны кабинетын боломж хэд дахин нэмэгджээ. Ийм удирдлагын тусгай программуудыг тухайн лингафоны кабинетыг угсарч өгөх пүүсээс санал болгодог. Тус кабинетыг тусгай сургалтгүйгээр эзэмшихэд хялбар бөгөөд зардал багатай төдийгүй нэг дор 24 хүртэлх оюутныг хичээллүүлэх боломжтой ажээ.

Гурав дахь төрөл болох компьютерын лингафон кабинет бол ерөнхийдөө локаль сүлжээнд холбогдсон персонал компьютеруудаас бүрддэг. Энэ лингафоны кабинетын компьютер болгон нь тусгай мультимедиа боломжтой байх ёстой. Өөрөөр хэлбэл, аудио болон видео дүрсийг дэлгэцээр гаргах болон чихэвчээр ч сонсох боломжтой байна. Багш болон сурагчдын компьютерууд лингафоны сүлжээний тусгай программ хангамжаар хангагддаг учраас ийм төрлийн кабинет ашиглахын өмнө багш нар төдийгүй сурагчдад тусгайлан заах шаардлагатай болдог ажээ. Бас оюутан болгонд нэг компьютер гаргаж өгөх шаардлагатай учраас уг кабинетыг худалдан авах зардал төдий хэмжээгээр өснө. Энэ төрлийн лингафоны кабинетад хиймэл дагуулын телевизийн сүлжээг залгах боломжтой.

Дөрөв дэх төрлийн лингафоны кабинет бол мобильный буюу нүүдлийн лингафоны кабинет юм. Ийм лингафоны кабинетыг дуртай газраа зөөж аваачих боломжтой байдаг байна. Багшийн хэрэгсэл төхөөрөмжийг ердөө л бага оврын цүнхэнд багтааж болдог. Энэхүү лингафоны кабинетын үндэс нь ноутбук компьютерын утасгүй сүлжээ юм. Уг сүлжээний үндсэн зарчим компьютерын лингафоны кабинеттай төстэй. Ганцхан персонал компьютеруудыг ноутбукээр сольсон явдал ажээ. Энэхүү лингафоны кабинет нь тусгай аккумулятор батарейгаар ажилладаг бөгөөд хаа ч

авч явж болох сайн талтай боловч, хамгийн их зардал гаргадаг байна. Уг лингафоны кабинетын жин дунджаар 8 кг байдаг аж.

Тав дахь төрлийн буюу хамгийн орчин үеийн лингафоны кабинет бол тоон лингафон кабинет юм. Ийм лингафоны кабинет дууны чанар болон ашиглалтын чадвараараа хамгийн өндөр шаардлагыг хангах чадвартай байдаг. Энэ лингафоны кабинет маш өндөр хүчин чадал бүхий багшийн толгой компьютер болон бүх тоон форматын аудио файлуудтай ажиллах боломжтой оюутнуудын компьютерын пультуудээс бүрддэг. Ийм Тоон лингафоны кабинетын бүх пультууд болон шингэн кристалл дисплей, тусгай мебель тавилга зэргийг бүгдийг нь ханган нийлүүлэгч пүүсээс хариуцдаг бөгөөд хэрвээ аль нэгэн бүрэлдэхүүн хэсгийг өөр гуравдагч газраас авбал уг лингафоны кабинетын дууны чанарт муугаар нөлөөлдөг ажээ. Тус лингафоны кабинетын дууны чанар нь ISO-9001 олон улсын стандартад тохирох ёстой байдаг.

МАНАЙ ОРОНД ХЭРЭГЛЭЖ БҮЙ ЛИНГАФОНЫ КАБИНЕТУУДЫН ТУХАЙД:

Манай улсын Их, дээд сургуулиудад өргөнөөр хэрэглэж байгаа уламжлалт лингафоны кабинетын тоноглол үндсэндээ хоёр сувгийн бичлэгтэй магнитофоны төхөөрөмж бүхий аналог лингафоны кабинет бөгөөд барагцаалбал 8-16 оюутныг нэг доор хичээллэх боломжтой лингафоны ширээ болон диктор багшийн төхөөрөмж зэрэг энгийн шийдэл дээр үндэслэгджээ.

Багш магнитофоны бичлэгийн дууг чангалах сулруулах боломжтой байхын зэрэгцээ кабинетад сууж байгаа оюутнуудыг нэг нэгээр нь дуудаж тэдний хариултыг хянах боломжтой. Мөн ийм кабинетад тусгайлан бэлдсэн лингафоны кабинетын сургалтын материалыг оюутнуудад сонсох боломжтой байдаг. ASC, Sony, Revox пүүсүүдэд хийсэн анхны лингафоны кабинетуудыг ийм загвараар бүтээсэн байна.

ЦААШИД ЛИНГАФОНЫ КАБИНЕТЫГ ШИНЭЧЛЭХ БОЛОН СУРГАЛТАД ҮР ДҮНТЭЙ АШИГЛАХАД АНХААРАХ ЗҮЙЛ:

Бид өөрийн сургуулийн лингафоны кабинетыг сайжруулахын тулд чухам ямар замаар явах вэ гэдэг асуудалд анхаарлаа хандуулъя. Эндээс үзэхэд аналог лингафоны кабинет техникийн хөгжлийн түвшинд хоцрогдож байгаатай холбоотойгоор бид Компьютерын лингафоны кабинетыг байгуулж, түүнийг сургалтад үр дүнтэйгээр ашиглах боломжийг судалж үзэх нь зүйтэй гэж үзэж байна. Манай оронд ашиглагдаж буй Компьютерын лингафоны кабинетуудыг их, дээд сургуульд өргөнөөр хэрэглэх болсон боловч энд хэд хэдэн дутагдалтай талууд ажиглагдаж байна. Эдгээрээс дурдвал:

1. Монголын их, дээд сургуулиуд Компьютерын лингафоны кабинетыг байгуулахдаа бүх зүйлийг компьютер хийж чадна гэдэг ойлголт хэт давамгайлснаас болж хэлний мэргэжлийн багшийн оролцоо багассан нь ажиглагдаж байна. Ийм лингафоны кабинетуудыг заримдаа англи хэлний мэргэжлийн багш биш, жирийн компьютерын мэргэжилтэн хүмүүс эрхэлж байгаа нь компьютерын лингафоны кабинетын ажилд сөргөөр нөлөөлж байна гэж үзэж болох талтай. Лингафоны кабинетыг ихэвчлэн гадаад хэлний авиа зүйн дуудлагыг зөв эзэмшүүлэхэд ашигладаг учраас энэ төрлийн дасгалыг дахин дахин давтах хэрэгцээ их гардаг тул энэ бүхнийг заавал хэлний мэргэжлийн хүний удирдлаган дор явуулах хэрэгтэй.

2. Орчин үеийн компьютерийн хүчин чадалд хэт шүтсэнээс болж зарим газрыг лингафоны кабинетын мөн чанарыг мартахад хүрчээ. Энэ бол акустикийн чанарыг хангасан лингафоны тусгаарлагдмал орчин бий болгох шаардлагыг ор тас мартсан явдал юм. Лингафоны кабинетад орж ирсэн суралцагч, оюутнууд гадаад ертөнцийн аливаа дуу шуугианаас бүрэн тусгаарлагдах ёстой байдаг. Энэ зарчмыг биелүүлэхгүй байснаас болоод ихэнх сургуулийн лингафоны

кабинетууд сүлжээнд холбогдсон хэдэн компьютер төдий болжээ.

3. Монголын лингафоны кабинетуудад акустикийн шаардлага хангасан, дуу шуугианыг тусгаарласан хана туурга байхгүй байна. Иймээс лингафоны кабинетыг байгуулахад зарцуулсан хөрөнгө ямар ч үр ашиггүй болох явдал гарах нь мэдээж юм.

4. Зарим их сургуулийн лингафоны кабинетын сургалтын чанар муу байгаа явдал нь тэнд акустикийн сахилга батыг чанд сахихгүй байгаатай холбоотой ажээ. Лингафоны кабинетад суралцагчид сургалтын материалыг сонсож байхад хажууханд нь өөр хүмүүс хүчтэй спикер буюу өсгөгч төхөөрөмжөөр хөгжим дууг сонсож байдаг.

5. Компьютерийн лингафоны кабинетын хамгийн гол төхөөрөмж чихэвч гэдгийг санах хэрэгтэй. Лингафоны кабинетын сургалтын чанарын 90 хувь нь чихэвчийн чанараас хамаардаг байна. Иймээс лингафоны кабинет байгуулахдаа тэнд ашиглаж байгаа компьютерүүдийн хүчин чадалд голлон анхаарах биш, хамгийн гол зүйл болох чихэвчин дээр хэмнэлт хийлгүйгээр, хямд үнэтэй, чанаргүй чихэвчийг авахаас зайлсхийх хэрэгтэй.

Эдгээр алдаатай талыг залруулж чадвал компьютерын лингафоны кабинетын чанарыг эрс сайжруулах боломжтой юм. Үүнээс гадна, лингафоны сургалтын чанарыг сайжруулах нэмэлт арга хэрэгслийг өргөнөөр хэрэглэж болно. Үүний тулд:

1. Хэлний сургалтад хэрэглэж болох аливаа программ хангамжийг өргөнөөр ашиглах. Одоо Барууны орнуудад TEXT –TO- SPEECH буюу текстийг компьютерын тусламжтайгаар уншдаг программ хангамжийг сургалтад өргөнөөр ашигладаг болсон байна. Мөн хэл яриаг таньж текст болгодог программ хангамжууд хэрэглэгдэж байгаа аж. Ийм программ хангамжуудыг лингафоны кабинетын хүрээнд өргөнөөр ашиглах нь компьютерын лингафоны кабинетын үр өгөөжийг эрс дээшлүүлэх боломжтой. "DRAGON Naturally speaking 8.0" зэрэг ийм тусгай программ хангамжийг интернетээр чөлөөтэй худалддаг

учраас эдгээрийг интернетээс татан авч сургалтад хэрэглэх боломж байна.

2. Сүүлийн үед барууны кинонууд дэлгэцийн доод талдаа титр үсэгтэй гарах нь их болсон. 1990-ээд оноос хойш Монголын телевизээр барууны олон киног Монгол хэлээр үзүүлсэн болохоор ихэнх хүмүүс тэдгээр кинонд гардаг үйл явдлыг маш сайн мэднэ. Харин шууд англи хэлээр нь үзэх нь ховор байдаг. Англи хэлээр нь үзэхэд эхлэн хэл сурч байгаа хүн шууд ойлгоход хэцүү байдаг. Харин киног субтитртэй гаргавал киноны гол баатруудын хэлж байгаа үг болгон текстэн хэлбэрээр киноны доод талд бичигдэх учраас маш ойлгомжтой болж ирдэг. Одоо интернетэд дунджаар 6000 орчим уран сайхны болон 2000 гаруй баримтат киноны субтитрууд байгаа гэсэн тооцоо байдаг. Англи хэл дээрх субтитр бүхий киноны хэсгийг лингафоны сургалтын явцад ашиглах оюутнуудын сонирхлыг татах ихээхэн ач холбогдолтой байдаг.

ДҮГНЭЛТ

Нэгэнт Аналог ажиллагаатай лингафоны кабинетууд үеэ өнгөрөөж байгаа учраас цэвэр аналог ажиллагаатай лингафоны кабинет авахаас зайлсхийх хэрэгтэй. Мультимедиа оролттой аналог лингафоны кабинетыг эзэмшихэд хялбар боловч, цаашид өргөжүүлэх болон хэлний сургалтын орчин үеийн программ хангамжийг ашиглахад төвөгтэй. Бас мобил лингафоны кабинет болон Тоон лингафоны кабинет зэрэг нь хамгийн орчин үеийн шийдэлтэй, хэрэгтэй бүх программ хангамж зэрэг нь гадаад орноос цогц байдлаар оруулж ирдэг учраас ийм лингафоны кабинетыг худалдаж авах нь хамгийн дээд зэргийн шийдэл болох нь дамжиггүй. Гэвч эдгээр Лингафоны кабинетын үнэ өндөр бөгөөд хэрэглэхэд заавал тусгай сургалт шаарддаг тул Монголын нөхцөлд ийм шийдлийг хийхэд хэцүү.

Эндээс үзэхэд лингафоны кабинетын компьютержсэн хувилбар болох компьютерын лингафоны кабинетыг сонгон авсан нь зүйтэй юм. Гэхдээ уг кабинетын үр өгөөжийг дээшлүүлэхийн тулд орчин үеийн

техник технологийн бидэнд олгож байгаа боломжийг аль болох өргөнөөр ашиглах нь чухал юм.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. www.worldenglishinstitute.org
2. <http://www.gymkvary.cz>
3. www.spse.pilsedu.cz
4. <http://www.esl.about.com/homework/esl/mbody.htm>
5. <http://www.englishpage.com>
6. <http://www.englishspace.ort.org>
7. <http://www.englishstudent.com/>
8. <http://www.mongoltoli.mn>

**Уншиж танилцан нийтлэхийг
зөвшөөрсөн, Сэтгүүлийн зөвлөлийн
гишүүн, хууль зүйн доктор
Б.Жаргалсайхан**



МОНГОЛЫН
ХУУЛЬ
САХИУЛАХ
УЧРААС